



“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

**АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САНГИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025.01.31

**БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛ, СТАНДАРТ НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТЭС**

Танилцсан:

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал
бөгөөд Авто замын норм нормативын сангийн
Удирдах зөвлөлийн дэд дарга



Д.ОЮУНБОЛД

Хянасан:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал,
стандарт норм нормативын хэлтсийн дарга

Г.АНХЦЭЦЭГ

Боловсруулсан:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал,
стандарт норм нормативын хэлтсийн Стандарт
норм норматив хариуцсан мэргэжилтэн

О.ДОЛГИОН

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	4
ХОЁР. САНГИЙН 2024-2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	4
ГУРАВ. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
3.1 Он дамжиж буй төсөл арга хэмжээ.....	5
3.2 Шинээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ	5
3.3. Редакц, шүүмж хийх үйл ажиллагаа	6
3.4. Төсөл арга хэмжээний санхүүжилт	6
ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
4.1 Сангийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа	6
ТАВ. САНГИЙН ХӨРӨНГӨ БҮРДҮҮЛЭЛТ	7
ЗУРГАА. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ	8
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ.....	9
ХҮСНЭГТ №1	9
ХҮСНЭГТ №2	15

АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нь Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.4 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дугаар тушаалаар батлагдсан “Авто замын норм нормативын сангийн ажиллах журам” (Сайдын 2020 оны А/121 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон)-ын дагуу Монгол Улсын авто зам, замын байгууламжийн стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

ХОЁР. САНГИЙН 2024-2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Авто замын норм нормативын сан”-гийн хөрөнгөөр 2024-2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахаар шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай стандарт, норм норматив, техникийн баримт бичиг, эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлын саналыг Зам тээврийн хөгжлийн яамны холбогдох газар, “Монголын авто замчдын холбоо” ТББ болон Нийслэлийн замын хөгжлийн газраас авч, нэгтгэн боловсруулан тус сангийн Удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.

Дээрх хурлаар **1,458,518,992.00** төгрөгийн үлдэгдэл санхүүжилттэй **46** төсөл, **2,553,747,500.00** төгрөгийн өртөг бүхий шинээр хэрэгжүүлэх **49** төсөл, **853,800,000.00** төгрөгийн өртөг бүхий **9** үйл ажиллагааны зардал, нийт **4,866,066,492.00** төгрөгийн **104** төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааны зардал батлагдсан.


Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 95 төсөл арга хэмжээг төрлөөр нь ангилбал:

Он дамжин хэрэгжиж буй **46** төсөл арга хэмжээнд шинээр болон шинэчлэн боловсруулах **11** стандарт, **21** норм дүрэм, **3** түүхэн ном болон туршилт судалгааны **11** төсөл арга хэмжээ тусгагдсан бол 2024-2025 онуудад шинээр хэрэгжих **49** төсөл, арга хэмжээнд шинээр болон шинэчлэн боловсруулах **27** стандарт /автотээврийн багц 3 стандарт/, **17** норм дүрэм, **3** туршилт судалгаа, Авто замын сүлжээ болон норм дүрмийн хүртээмжийг сайжруулахтай холбоотой цахимжуулах **2** ажил тус тус тусгагдсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 95 төсөл арга хэмжээг төсөвт өртгөөр нь ангилбал:

Төлөвлөгөөнд **2,501,325,631.00** төгрөгийн өртөг бүхий шинээр болон шинэчлэн боловсруулах **41** норм, **581,025,400.00** төгрөгийн өртөг бүхий **38** стандарт, **195,000,000.00** төгрөгийн өртөг бүхий цахимжуулах **2** ажил, **734,915,461.00** төгрөгийн өртөг бүхий **14** судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

**Сангийн хөрөнгөөр 2024-2025 онд хэрэгжүүлэх төслийн тоо,
хөрөнгийн хэмжээ**



Батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 03 сарын 11-ний өдрийн 1/309, 1/310, 1/311 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газар болон Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, Авто замын бодлого зохицуулалтын газарт тус тус хүргүүлсэн.

ГУРАВ. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


3.1 Он дамжиж буй төсөл арга хэмжээ

Сангийн төлөвлөгөөнд он дамжин хэрэгжиж буй **46** төсөл, арга хэмжээнээс **15**-н төсөл арга хэмжээ бүрэн дуусаж, холбогдох тогтоол шийдвэрүүдээр баталгаажсан бол **1** төсөл арга хэмжээ батлагдах шатанд, **1** төсөл арга хэмжээ дуусах шатанд, **19** төсөл арга хэмжээ эцсийн шатанд, байгаа бол үлдсэн **9** төсөл, арга хэмжээ нь дунд шатанд байна. **1** төсөл арга хэмжээний гэрээг цуцлахаар ажиллаж байна. /Хүснэгт №1/

3.2 Шинээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ

Шинээр хэрэгжүүлэх **49** төсөл арга хэмжээнээс **5** төсөл арга хэмжээ эцсийн шатанд, **31** төсөл арга хэмжээ буюу 3-багц 21 стандарт нь дунд шатанд, **1** төсөл арга хэмжээ эхлэлийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна. Зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг зарлах **4** төсөл, ажлын даалгавар шинэчлэх, батлуулахтай холбогдуулан нэмэлт судалгаа хийгдэж зарлагдаагүй **7** төсөл арга хэмжээ **1** төсөл арга хэмжээг боловсруулах шаардлагагүй болсон тул төлөвлөгөөнөөс хасагдсан байна. /Хүснэгт №2/

Сангийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт **95** төсөл, арга хэмжээний **15** нь бүрэн дууссан, **1** төсөл арга хэмжээ батлагдах шатанд, **25** нь дуусах болон эцсийн шатанд, **40** буюу 3 багц-21 стандарт дунд шатанд, **1** нь эхлэлийн шатанд, **4** нь сонгон шалгаруулалтын шатанд, үлдсэн **7** нь ажлын даалгаврыг шинэчлэн сонгон шалгаруулалтыг зарлах төсөл байна. **1** төсөл арга хэмжээг боловсруулах шаардлагагүй болсон тул төлөвлөгөөнөөс хасагдсан байна. Үүнээс **1** төсөл арга хэмжээ гэрээ цуцлахаа ажиллаж байна.



3.3. Редакц, шүүмж хийх үйл ажиллагаа

Сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний үе шатны тайлан, төсөлд редакц, шүүмж хийх ажлын хэсгийг Захирлын тушаалаар томилон 2024-2025 онд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд давхардсан тоогоор нийт **30** төсөл арга хэмжээний ажлын хэсэгт **40,360,628** төгрөгийн цалин урамшууллыг журмын дагуу тооцож, батлуулан гишүүдэд олгосон байна.

3.4. Төсөл арга хэмжээний санхүүжилт

Батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа болон шинээр гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тодорхой төлбөрийн санхүүжилтийн хуваарийг гүйцэтгэлийн хамт боловсруулан давхардсан тоогоор **нийт 82** төсөл арга хэмжээний **1,548,095,013** төгрөгийн хүсэлтийг Зам, тээврийн яамны Санхүүгийн хэлтэст 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 1/119, 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/207, 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/393, 05 дугаар сарын 06-ны өдрийн 1/512, 05 дугаар сарын 22-ны 1/677, 06 дугаар сарын 19-ны өдрийн 1/781, 07 дугаар сарын 26-ны өдрийн 1/923, 08 дугаар сарын 16-ны өдрийн 1/996, 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1/1074, 11 дүгээр сарын 04-ний өдрийн 1/1325, 11 дүгээр сарын 18-ны 1/1416, 12 дугаар сарын 02-ны 1/1456, 12 дугаар сарын 06-ны 1/1513, 12 дугаар сарын 19-ны өдрийн 1/1577 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, эрх нээлгэн Төвийн нормативын дансанд төвлөрүүлэн ажилласан.

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Сангийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа

“Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2024 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө”-г Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу боловсруулж, Төрийн худалдан авах ажиллагааны газар болон Сангийн яаманд цахим хүсэлт гарган баталгаажуулж ажилласан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу төсөл арга хэмжээг “**Бусдаар гүйцэтгүүлэх**” буюу нээлттэй тендер шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хүрээнд Төрийн худалдан авах www.tender.gov.mn системээр зарлан зохион байгуулан ажиллаж байна.

Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан **2,503,747,500** төгрөгийн өртөг бүхий шинээр хэрэгжүүлэх **49** төслийн төсөвт өртгөөс хамааруулж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар **3**, харьцуулалтын аргаар **32** төсөлд зөвлөхийг сонгон шалгаруулсан бол **4** төслийг шууд худалдан авах аргаар нийт **1,067,688,000** төгрөгийн өртөгтэй нэр бүхий **39** төслийн зөвлөхийг сонгон шалгаруулж, тендерийн хүчинтэй хугацаанд буюу тендер нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хэлэлцээр хийн гэрээ байгуулсан.

Зөвлөхийг сонгон шалгаруулах нэр бүхий **1** төсөлд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй тендер зарлан ажиллаж байна. Мөн **9** төсөлд ажлын даалгавар шинэчлэх, батлуулахтай холбогдуулан нэмэлт судалгаа хийгдэж зарлагдаагүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй болно.

Тус газар нь “Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2024 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө”-нд тусгагдаагүй худалдан авалтыг зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны явцад аливаа зөрчил гараагүй болно.


ТАВ. САНГИЙН ХӨРӨНГӨ БҮРДҮҮЛЭЛТ

“Авто замын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтад **Авто замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгийн 0.4%-аар тооцсон орлогоос “Авто замын норм нормативын сан”-г бүрдүүлэхээр заасан.**

Сангийн хөрөнгө бүрдүүлэлтэд улсын төсвөөс хэрэгжиж буй Авто замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгөөс 0.4%-аар тооцсон орлогыг Зам, тээврийн яамны Санхүүгийн хэлтэст хянагдаж, төрийн санд төвлөрүүлж байна.

2024 оны эхний үлдэгдэл **3,820,007,812** төгрөг үүнээс төвлөрсөн орлого **5,105,038,178** төгрөг нийт **8,925,045,990** төгрөг байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн авто замын барилга угсралт, засвар, арчлалтын ажлын **1,587,506,043** төгрөг, Нийслэл болон Барилга хот байгуулалтын яамнаас **1,097,089,174** төгрөг. Бусад төсөл хөтөлбөрүүдээс (Төмөр зам, Иргэний нисэх) **2,399,295,725** Орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс **12,661,636** төгрөг, Норм дүрэм техникийн баримт бичиг борлуулсны орлогын **8,485,600.00** төгрөгөөс тус тус бүрдэж байна.

АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САНД ТӨВЛӨРСӨН ОРЛОГЫН ХЭМЖЭЭ САЛБАР ТУС БҮРЭЭР



ЗУРГАА. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.5, 8.9.8-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх завсрын аудитын ажил эхэлж “Авто замын норм, нормативын сан”-гийн 2024 эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, баримтын бүрдэлд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авто замын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилт, ерөнхий шаардлага стандарт, улсын байцаагчийн эрх үүргийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-ны хугацаанд аудитын түүвэрт хамрагдаж хяналт, шалгалт, дотоод аудит хийгдсэн.

--oOo--

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

ХҮСНЭГТ №1

Он дамжсан 46 төсөл, арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
Бүрэн дууссан 15 төсөл					
1	“Авто зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг шинэчлэн боловсруулах	"Монголын авто замчдын холбоо" ТББ	132,275,000	100%	Зам, тээврийн Сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/243 дугаар тушаалаар батдагдаж. Хууль зүйн дотоод хэргийн яамны эрх зүйн баримт бичгийн актад 4457 дугаарт бүртгүүлэв.
2	“Авто зам, замын байгууламжийн машин, механизмын ашиглалтын нэг машин цагийн үнэ” шинэчлэн боловсруулах				
3	Авто замын төслийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцох аргачлал боловсруулах	"Интегрити инженеринг" ХХК	186,237,512	100%	Ажлын даалгаварт заасан үүргийн биелэлт бүрэн хэрэгжсэн бөгөөд батлуулахаар аргачлалын төслийг Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
4	MNS 6444:2014 “Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг шинэчлэх	"Ай Си Си Рөүд" ХХК	20,000,000	100%	Стандарт хэмжил зүйн газрын 2024 оны С/18 дугаар тушаалаар батлагдсан.
5	Хурд сааруулагчийн жишиг зургийн цомог боловсруулах	"Ай Си Си Рөүд" ХХК	20,000,000	100%	Стандарт хэмжил зүйн газрын 2024 оны С/18 дугаар тушаалаар батлагдсан.
6	Авто тээврийн хэрэгсэлд байрлуулах RFID шошгоны тухай стандарт боловсруулж, батлуулах	"ММЗөвлөх инженерүүдийн холбоо" ТББ	19,700,000	100%	Стандарт хэмжил зүйн газрын Харилцаа холбооны стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн дэмжигдсэн.
7	MNS 6278:2011 “Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг шинэчлэн боловсруулах	"Зам тээврийн хүрээлэн" НҮТББ	20,000,000	100%	Эцсийн төслийг Стандарт хэмжил зүйн газрын Стандарчиллын техникийн хороогоор хэлэлцэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
8	MNS 4598:2020 "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" стандартыг шинэчлэн боловсруулах		15,000,000	100%	Эцсийн төслийг Стандарт хэмжил зүйн газрын Стандарчиллын техникийн хороогоор хэлэлцэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
9	MNS 5345:2011 "Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага"		20,000,000	100%	Эцсийн төслийг Стандарт хэмжил зүйн газрын Стандарчиллын техникийн хороогоор

Он дамжсан 46 төсөл, арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
	стандартыг шинэчлэн боловсруулах				хэлэлцэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
10	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шинэ техник, технологийн стандарт боловсруулах	"Авто тээврийн үндэсний төв"	21,200,000	100%	Эцсийн төслийг Стандарт хэмжил зүйн газрын Стандарчиллын техникийн хороогоор хэлэлцэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
11	ISO39001:2012 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх судалгаа	"Удирдах хөгжил урлаг"ТББ	19,900,000	100%	Зөвлөхийн боловсруулсан эцсийн тайланг акт үйлдэн хүлээн авахаар ажиллаж байна.
12	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс ялгарах хорт хийн (CO, HC, NOx, PM болон бусад) агууламжийг хянах тогтолцоог боловсронгуй болгох судалгаа	"ШУТИС-Механик, тээврийн сургууль"	175,000,000	100%	Эцсийн төслийг Зам тээврийн яамны Автотээврийн салбарын Шинжлэх ухаан технологийн дэд зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд гэрээт ажлын хүрээнд худалдан авсан багаж, тоног төхөөрөмжийг акт үйлдэн хүлээн авсан.
13	Олон улс, улсын чанартай авто замд баригдсан ус зайлуулах байгууламжид үзлэг судалгаа хийж, шар усны үер, гадаргуун ус нэвтрүүлэх чадварыг шинэчлэн тооцох судалгаа (1-р судалгааны зам: A0201-A0202 чиглэл)	"Keapo" ХХК	93,170,484	100%	Судалгааны ажлын эцсийн төслийг Зам, тээврийн яамны Авто замын салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
14	Тоосжилт ихтэй болон эвдрэл их үүсдэг давааны хучилтгүй хөрсөн хэсгийг тусгай барьцалдуулагч бодисоор бэхжүүлэх туршилт, судалгаа /Тэрэлж../	"Ай Руд" ХХК	294,137,910	100%	Судалгааны тайланг Авто замын салбарын Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурал болон Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авсан.
15	"Монгол Улсын авто замын орон зайн мэдээллийн санд суурилсан веб аппликейшнд улсын чанартай авто замын судалгааны мэдээллийг оруулах, вэб аппликейшнг мэргэжлийн хэрэглээний	"Азийн дэд бүтцийн хөгжлийн судалгааны хүрээлэн" ТББ	181,800,000	95%	Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд гүйцэтгэсэн эцсийн төслийг Авто замын салбарын Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн

Он дамжсан 46 төсөл, арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
	түвшинд ашиглах дадлагыг бий болгох, олон улсын стандартын түвшинд нэгдсэн мэдээллийн системийг бий болгох" төслийн үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх				дэмжигдсэн ба тус газрын захирлын баталсан тушаалын дагуу хүлээн авах ажлын хэсэг байгуулагдаж ажлын хэсгийн хурлын шийдвэрийг үндэслэн гэрээт ажлыг акт үйлдэн хүлээн авав. Гэрээний дагуу баталгаат хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгүүлж байна.
Батлагдах шатанд 1 төсөл					
1	БНБД 32-01-04 "Хот суурины гудамж, зам төсөллөлт"-г шинэчлэн боловсруулах	"Гео зураглал" ХХК,	53,955,000	90%	Нормыг шинэчлэх ажлын даалгаврыг 2018 онд боловсруулсан ба сангийн төлөвлөгөөнд тусган батлуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулан гэрээг 2019.02-р сард байгуулсан. Шинэчилсэн төсөл 2021.08.20-нд Авто замын салбарын ШУТЗ-өөр дэмжигдсэн. Сайдын тушаалаар батлуулах хүсэлтийг 2021 оны 1/628 тоотойр 3ТХЯаманд хүргүүлсэн. 3ТХЯ-аас 2023.01-сард 01/369 тоотойр хуучин 2004 оны нормыг хүчингүй болгуулах хүсэлтийг БХБЯ-руу хүргүүлсэн. БХБЯ-аас МУЗГ-ын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын тогтолцоо"-ны шаардлагыг хангуулахаар буцаагаад байгаа.
Дуусах шатанд 7 төсөл					
1	АЗУАГН 2.01.01-2004 "Авто замын уур амьсгал геотехникийн нөхцөл" нормыг шинэчлэн боловсруулах	"Саго трейд" ХХК	46,000,000	90%	Эцсийн төслийг Авто замын салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлж, хурлаас гарсан зөвлөмжийн дагуу нормын төсөлд нэмэлт сайжруулалт хийж дахин хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
Эцсийн шатанд 18 төсөл					
1	Асфальтбетон хучилтын геотор материалын техникийн шаардлага боловсруулах	"Жи Эс Эл Интернэшнл Консалтинг" ХХК	20,000,000	80%	Редакц, шүүмжийн ажлын хэсгээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу эцсийн шатны тайланд засвар сайжруулалтыг гүйцэтгэж байна.

Он дамжсан 46 төсөл, арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
2	"Авто зам, замын байгууламжийн нормативт хугацааны суурь норм"-ыг шинэчлэх	"Монголын авто замчдын холбоо" ТББ	85,800,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайланд редакц, шүүмжийн санал дүгнэлтийн дагуу сайжруулалтыг гүйцэтгэж байна.
3	Гүүр барих нормативт хугацааг шинэчлэн боловсруулах				
4	Авто зам, гүүрийн барилга, засвар арчлалтын ажлын үе шатны ажлуудад ноогдох ИТА-ны цагийн томсгосон норм боловсруулах				
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн асуудал буюу налуу замын жишиг зургийн цомог боловсруулах	"Монголиан Нэйшнл Хайвэй" ХХК	20,000,000	80%	Зөвлөх үйлчилгээний эхлэлийн шатны тайланд Редакци, шүүмжийн ажлын хэсгээс гаргасан санал зөвлөмжийн дагуу эцсийн шатны тайланд засвар сайжруулалтыг гүйцэтгэж байна.
6	Гүүрийн алгасал байгууламжийг тооцоот ачаалал (статик & динамик) - р туршиж баталгаажуулах гарын авлага боловсруулах	"Брос проперти" ХХК	18,000,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
7	Төмөрбетон хийцийн хэв хашмал & тулаасны гарын авлага боловсруулах	"Брос проперти" ХХК	16,000,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
8	Гүүрийн хэв гажилтын заадас, тулах хэсэг, хүчитгэлийн тросс, хүчитгэлийн зайлшгүй дагалдах хэрэгсэлүүдэд тавигдах шаардлага боловсруулах	"Брос проперти" ХХК	15,000,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
9	Авто замын зэргэлдээх нутаг дэвсгэрийг тээврийн хэрэгслээс үүсэх дуу чимээнээс хамгаалах аргачлал боловсруулах	"Гео урбан консалтинг" ХХК	35,500,000	80%	Гэрээний дагуу эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
10	Аюулгүйн тойрог төлөвлөх аргачлал боловсруулах	"Гео урбан консалтинг" ХХК	34,394,400	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
11	AASHTO R 28:2022 Даралтаар өгөршүүлэх багаж (PAV) ашиглан битумын өгөршлийг түргэсгэх аргын стандартыг шинэчлэн боловсруулах	"Монголиан Нэйшнл Хайвэй" ХХК	14,916,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
12	ASTM D 4429 "Талбайн ачаа даац тодорхойлох" туршилтын стандартыг орчуулан боловсруулах	"Монголиан Нэйшнл Хайвэй" ХХК	10,065,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
13	ASTM E 2835-11 "Хөнгөн ачаатай дефлектометр" стандартыг орчуулан боловсруулах	"Монголиан Нэйшнл Хайвэй" ХХК	19,228,000	80%	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.

Он дамжсан 46 төсөл, арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
14	Шилэн мяндасаар хүчитгэсэн халуун асфальтбетон хольцыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх туршилт, судалгаа	"Жи Эс Эл Консалтинг" ХХК	20,000,000	80%	Эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
15	Wetsort материалыг зам барилгын ажилд хэрэглэх, технологийг нэвтрүүлэх судалгаа	"Лабo" ХХК	15,000,000	80%	Редакц шүүмжийн ажлын хэсгээс гарсан санал дүгнэлтийн дагуу эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
16	Нано бактерийн судалгаа	"Смарт лаб" ХХК	16,000,000	80%	Редакц шүүмжийн ажлын хэсгээс гарсан санал дүгнэлтийн дагуу эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
17	TERRA-4000 бэхжүүлэгч материалыг зам барилгын ажилд хэрэглэх туршилт судалгаа	"Смарт лаб" ХХК	20,000,000	80%	Редакц шүүмжийн ажлын хэсгээс гарсан санал дүгнэлтийн дагуу эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
18	Хот, суурин газрын гудамж замын зураг төсөл боловсруулах үнэ тогтоох суурь судалгаа /Тохижилт болон инженерийн байгууламж бүгд тооцогдоно/	"Шарк Танк" ХХК	20,000,000	80%	Эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
Дунд шатанд 9 төсөл					
1	"Монгол Улсын авто замын салбарын түүхэн хөгжил" ном бүтээх	Зөвлөх баг	40,000,000	60%	Дунд шатны тайлан боловсруулалтын шатанд.
2	"Монголын авто зам 2009-2019" ном бүтээх		20,000,000	60%	Дунд шатны тайлан боловсруулалтын шатанд.
3	ЗЗБНБД 22- 004- 2016 "Авто зам төсөллөх" нормыг шинэчлэн боловсруулах	"Эм Си Пи Си Жи Ар" ХХК	139,780,310	60%	Дунд шатны тайлан боловсруулалтын шатанд.
4	"Хучилтын тооцооны гарын авлага" норм боловсруулах			60%	
5	БНБД 32.02.11 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" нормыг шинэчлэн боловсруулах	"ГБЭТ" ХХК	300,000,000	60%	Дунд шатны тайланд Редакц, шүүмжийн ажлын хэсгээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу шаардлагатай нэмэлт сайжруулалтыг гүйцэтгэж байна. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа асуудлаар Зөвлөхөөс хүсэлт ирүүлээд байгаа тул судалж, шийдвэрлэхээр ажиллаж байна.

Он дамжсан 46 төсөл, арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
6	"Модон гүүрийн барилгын ажлын төсвийн жишиг норм", "Ган гүүрийн барилгын ажлын төсвийн жишиг норм" боловсруулах	"Монголын авто замчдын холбоо" ТББ	100,000,000	60%	Дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
7	НАСТО олон улсын байгууллагын гаргадаг "Хотын тээврийн сүлжээний төлөвлөлтийн гарын авлага"-г шинээр боловсруулах	"Брос проперти" ХХК	30,439,200	60%	Дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
8	"Монгол орны асфальтбетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог" шинэчлэх.	"Ай Си Си Рөүд" ХХК	87,760,035	60%	Дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
9	Цэвдэгт бүс нутагт баригдсан авто замын өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээг тодорхойлох судалгаа	"Гео урбан консалтинг" ХХК	99,991,040	60%	Гэрээний дагуу боловсруулан ирүүлсэн дунд шатны тайланд редакц шүүмж хийх ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.

Шинээр хэрэгжих 49 төсөл арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
Эхлэлийн шатанд 1 төсөл					
1	"1520 мм царигтай төмөр замын зам" стандартыг боловсруулах.	"Мөнгөн зөрлөг" ХХК	49,000,000	30%	Гэрээний дагуу эхлэлийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
Дунд шатанд 31 төсөл /3 багц-21 стандарт/					
1	"Гэрлэн дохио суурилуулах, засварлах, арчлах ажлын үйлдвэрлэлийн болон төсвийн жишиг норм" шинэчлэн боловсруулах	"Монголын авто замчдын холбоо" ТББ	40,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
2	Гудамж замын гадаргуун ус зайлуулах байгууламжийн бүтээцийн жишиг зургийн цомог боловсруулах	"Ай Си Си Рөүд" ХХК	62,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
3	"Төмөрбетон гүүрийн нарийвчилсан үзлэг, оношилгоо хийх заавар"-ыг шинэчлэн боловсруулах	"Ай Си Си Рөүд" ХХК	51,900,000	60%	Гэрээний дагуу боловсруулан ирүүлсэн дунд шатны тайланд редакц шүүмж хийх ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.
4	"Гүүрэн байгууламжид арчлалт засвар хийх гарын авлага"-ыг шинэчлэн боловсруулах	"Ай Си Си Рөүд" ХХК	64,700,000	60%	Гэрээний дагуу боловсруулан ирүүлсэн дунд шатны тайланд редакц шүүмж хийх ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.
5	"Гүүрийн хяналтын инженерийн гарын авлага"-ыг шинээр боловсруулах	"Ай Си Си Рөүд" ХХК	64,800,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
6	"Явган хүний нийлмэл гүүр төсөллөх" нормыг шинээр боловсруулах	"Ай Си Си Рөүд" ХХК	49,900,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
7	Нэг түвшний уулзвар ба огтлолцлыг төсөллөхөд тавигдах шаардлага	"Аттовэй дизайн" ХХК	164,313,000	60%	Гэрээний дагуу боловсруулан ирүүлсэн дунд шатны тайланд редакц шүүмж хийх ажлын хэсэгт хянагдсаны дагуу засавар сайжруулалт хийгдэж байна.
8	Зорчигч тээврийн нэр бүхий 9 стандартыг шинэчлэн боловсруулах	"ММЗөвлөх инженерүүдийн холбоо" ТББ	30,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
9	Ачаа тээврийн нэр бүхий 6 стандартыг шинэчлэн боловсруулах	ШУТИС-Бизнесийн ахисан түвшний сургууль	30,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
10	ISO 16844-1-4:2022, ISO 16844-6-7:2022 Road vehicles-багц нэр бүхий 6 стандартыг шинээр боловсруулах	"ММЗөвлөх инженерүүдийн холбоо" ТББ	60,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.

Шинээр хэрэгжих 49 төсөл арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
11	"Хүйтэн асфальтбетон хольц. Техникийн шаардлага" боловсруулах	"Шарк Танк" ХХК	17,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
12	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ болон техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаанд даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх судалгаа	"ШУТИС-Бизнесийн ахисан түвшний сургууль"	40,000,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
13	Мэдээлэлийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх зөвлөх үйлчилгээ	"Монголын кибер довтолгоотой тэмцэх төв" ТББ	94,800,000	60%	Гэрээний дагуу дунд шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
Эцсийн шатанд 5 төсөл					
1	ЗЗБНБД 81-013-2019 "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм"-ыг шинэчлэн боловсруулах	"Монголын авто замчдын холбоо" ТББ	98,500,000	80%	Гэрээний дагуу эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
2	"Авто зам, замын байгууламжийн барилга, шинэчлэлт, их засварын техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) ба техник-эдийн засгийн тооцоолол (ТЭЗТ) боловсруулах, тэдгээрийн чанарыг үнэлэх, хүлээн авах, батлах заавар" боловсруулах	Монгол Улсын Зөвлөх инженер Р.Балжир	17,000,000	80%	Баримт бичгийн эцсийн төслийг танилцуулж, санал авахаар Авто замын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагууд хүргүүлэн хамтран ажиллаж байна.
3	MNS ASTM D3910:2008 "Сларри сийл-ийг төсөллөх, турших ба барих үед хэрэглэх заавар" стандартыг шинэчлэн боловсруулах	"Шарк Танк" ХХК	19,900,000	80%	Гэрээний дагуу боловсруулан ирүүлсэн эцсийн шатны тайланд редакц шүүмж хийх ажлын хэсэгт хянагдаж байна.
4	ASTM D 4215-21 "Хүйтэн асфальтбетон хольц" стандартыг боловсруулах	"Шарк Танк" ХХК	19,000,000	80%	Гэрээний дагуу боловсруулан ирүүлсэн эцсийн шатны тайланд редакц шүүмж хийх ажлын хэсэгт хянагдаж байна.
5	Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоор дамжуулж, их өгөгдлийг үүсгэх, олон нийтэд нээлттэй мэдээлэл хүргэх портал сайт хөгжүүлэлт	"Интерактив" ХХК	94,875,500	80%	Гэрээний дагуу эцсийн шатны тайлан боловсруулалтын шатанд байна.
Сонирхогч этгээдийн тоо хуулийн шаардлагад нийцээгүй, тендер амжилтгүй болж дахин зарласан 5 төсөл					
1	ЗЗБНБД 84-021-2016 "Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм"-ыг шинэчлэн боловсруулах	-	42,000,000	-	Тендерийн шатанд
2	ЗЗБНБД 31-008-2016 "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага"-ыг шинэчлэх	-	123,600,000	-	Тендерийн шатанд

Шинээр хэрэгжих 49 төсөл арга хэмжээ					
№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Дүн сая ₮	Явц	Хэрэгжилт
3	"Ус зайлуулах байгууламжийн загвар гарын авлага" боловсруулах	-	145,000,000	-	Тендерийн шатанд
4	Олон улс, улсын чанартай авто замд баригдсан ус зайлуулах байгууламжид үзлэг судалгаа хийж, шар усны үер, гадаргуун ус нэвтрүүлэх чадварыг шинэчлэн тооцох судалгаа (Налайх-Чойр-Сайншанд 2-р судалгааны зам: А0101, А0102, А0103 чиглэл)	-	138,847,500	-	Тендерийн шатанд
5	Монгол Улсын төмөр замын тээврийн тариф тогтоох аргачлал боловсруулах	-	580,000,000	-	Зам, тээврийн яамны ТНБД-ын баталсан Ажлын даалгаврын хүрээнд Үнэлгээний хороо сонгон шалгаруулалтын ТББ боловсруулж байна. Төмөр зам далайн тээврийн бодлого зохицуулалтын газраас санал авч батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
Ажлын даалгавар шинэчлэх, батлуулахтай холбогдуулан нэмэлт судалгаа хийгдэж зарлагдаагүй байгаа 5 төсөл					
1	"Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг тооцож олгох журам" боловсруулах	-	18,850,000	-	Ажлын даалгаварт Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
2	"Авто зам, замын байгууламжид хэрэглэх материалуудын нэгж хүнд, ачааны зэрэг, хорогдолыг тодорхойлох заавар" боловсруулах	-	50,000,000	-	Ажлын даалгаварт Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
3	"Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал"-ыг шинэчлэн боловсруулах	-	50,000,000	-	Ажлын даалгаварт Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
4	Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх гэрээний үнийн тохируулга хийх нөхцөл, аргачлал боловсруулах	-	50,000,000	-	Ажлын даалгаварт Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
5	Шугаман байгууламж (Авто зам, Төмөр зам)-ийн ус зүйн болон гидравликийн тооцооллыг тооцох арга,	-	50,000,000	-	Ажлын даалгаварт Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч

	аргачлалыг шинэчлэх, боловсронгуй болгох суурь судалгаа				батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
6	"Авто зам, замын байгууламжийн уян хучлагын дүрэм"-ийг дагаж мөрдөгдөх багц-26 стандарт боловсруулах	-	200,000,000	-	Ажлын даалгаварт Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч батлуулснаар сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.

---oOo---

"АВТО ЗАМЫН НОРМ НОРМАТИВЫН САН"-ГИЙН ХӨРӨНГӨӨР 2024-2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Нэг. Он дамжин шилжиж байгаа төсөл, арга хэмжээ										
№	Төсөл, арга хэмжээний чиглэл, нэр	Гэрээний дүн, ₮	Өмнө олгосон дүн, ₮	2024-2025 онд олгох дүн, ₮	Санхүүжилт		Хэрэгжүүлэх байгууллага, гэрээ №	Явц	Төрөл	
1.1 Норм норматив, техникийн баримт бичиг										
1.1.1	БНБД 32-01-04 "Хот суурины гудамж, зам төсөллөлт"-г шинэчлэн боловсруулах	53,955,000	48,559,500	5,395,500	-		"Гео зураглал" ХХК, 2019/14	Нормыг шинэчлэх ажлын даалгаврыг 2018 онд боловсруулсан ба сангийн төлөвлөгөөнд тусган батлуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулан гэрээг 2019.02-р сард байгуулсан. Шинэчилсэн төсөл 2021.08.20-нд Авто замын салбарын ШУТЗ-өөр дэмжигдсэн. Сайдын тушаалаар батлуулах хүсэлтийг 2021 оны 1628 тоотойр 3ТХЯ-аманд хүргүүлсэн. 3ТХЯ-аас 2023.01-сарад 01/369 тоотойр хуучин 2004 оны нормыг хүчингүй болтуулах хүсэлтийг БХБЯ-руу хүргүүлсэн. БХБЯ-аас МУЗГ-ын 2019 оны 106 дугаар тоотойр батлагдсан "Барилгын тогтолцоо"-ны шаардлагыг хангуулах чиглэл ирсэн. Чиглэлийн дагуу БХБЯ-тай ажлын даалгаврыг хамтран батлуулах, БХТөөөөс шинэчилсэн нормын төсөлд санал авч ажиллаж байна. Гэрээ, Ажлын даалгаварт заасан үүргийн биелэлт бүрэн хэрэгжсэн ба баталгаажуулах асуудлаар Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж байна.	Батлагдах шатанд	Норм
1.1.2	АЗУАНГ 2.01.01-2004 "Авто замын уур амьсгал геотехникийн нөхцөл" нормыг шинэчлэн боловсруулах	46,000,000	41,400,000	4,600,000	-		"Саго трейд" ХХК 2020/331	Авто замын салбарын Шинэлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу Монгол Орны 1. Авто замын уур амьсгалын бүс, дэд бүсчлэл дэх сарын, хоногийн болон өдрийн агаарын дундаж температур; 2. Авто замын уур амьсгалын бүс, дэд бүсчлэл дэх сарын хур тунадасны дундаж хэмжээ, аадар борооны давтамж /олон жилийн дунджаар болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр өөрчлөгдсөн дундаж үзүүлэлт/ 3. Авто замын уур амьсгалын бүс, дэд бүсчлэл дэх хөрсний чийгийн дундаж үзүүлэлт /сараар/, хөрсний хөдөлтийн дундаж гүн; 4. Авто замын уур амьсгалын бүс, дэд бүсчлэл дэх хөрсний чийгийн дундаж үзүүлэлт /сараар/, чийгийн эх сурвалж. Дундаж мэдээллийг нэмэлт судалгаа хийж байна. Мөн тус сангийн хөрөнгөөр боловсруулж буй "Авто замын уур амьсгалын төсөллөх дүрэм"-ийн шинэчлэлттэй уялдуулан ажиллаж байна. Ажлын даалгаварт заасан үүргийн биелэлт бүрэн хангагдсан бөгөөд ШУТЗ-өөс өгсөн зөвлөмжийн мөреэр шаардлагатай арга хэмжээг Ус зүй цаг уур хүрээлэнгийн газар болон Геофизикийн хүрээлэнгтэй хамтран ажиллаж байна.	Дуусах шатанд	Норм
1.1.3	"Монгол Улсын авто замын салбарын түүхэн хөгжил" ном бүтээх	40,000,000	12,000,000	28,000,000	-		Зөвлөх баг, 2022/490, 491	Энэхүү ном нь Авто замын салбарын үе үеийн түүхэн хөгжлийг өгүүлсэн байх бөгөөд Номын төслийг хянан тохиолдуулж байгаа ба нэмэлт архивын судалгаа хийгдэж байна. Авто замын салбарын 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд нэмэлт баяжуулалт, сурвалжлага хийхээр ажиллаж байна. Гэрээний үүрэг хангагдсан боловч Захиалагчаас нэмэлт судалгаа хийх чиглэл өгсөний дагуу нэмэлт боловсруулалт хийгдэж байна.	Дунд шатанд	Норм
1.1.4	"Монголын авто зам 2009-2019" ном бүтээх	20,000,000	6,000,000	14,000,000	-			Дунд шатанд	Норм	
1.1.5	33БНБД 22- 004- 2016 "Авто зам төсөллөх" нормыг шинэчлэн боловсруулах	139,780,310	27,956,062	111,824,248	-		"Эм Си Пи Си Жи Ар" ХХК 2021/174	Зөвлөх байгууллагаас авто замын төсөллөлтийн үндсэн нормыг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээндээ салбарын стандарт норм дүрмийн тогтолцоог шинэчлэх саналыг дэвшүүлж, улмаар MNS 6598:2016 "Зам, замын байгууламжийн норматив техникийн баримт бичгийн өрөнхий тогтолцоо"-ны стандартыг шинэчлэн Авто замын салбарын стандартчлалын техникийн хороогоор батлуулсан. Батлагдсан тогтолцооны стандартын дагуу Авто замын төсөллөлтийн баримт бичгийн иж бүрдлийг бий болгох, гэрээний хүрээнд 16 баримт бичгээс 8 баримт бичиг боловсруулахаар тогтсон. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дээрх зураг төслийн баримт бичгийн иж бүрдэлд эцэслэн санал, шийдвэр гаргуулахаар ажиллаж байна. Шийдвэр гарснаар гэрээг дүгнэж, сунган ажиллах болно.	Дунд шатанд	Норм
1.1.6	"Хучилтын тооцооны гарын авлага" норм боловсруулах							Дунд шатанд	Норм	
1.1.7	Асфальт-бетон хучилтын геостор материалын техникийн шаардлага боловсруулах	20,000,000	10,000,000	10,000,000	6,000,000		Жи Эс Эл Интернашл Консалтинг ХХК, 2023/03-10	Гэрээг ажлын хүрээнд боловсруулсан дунд шатны тайланд Редац, шүүмжийн ажлын хэсгээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу зэсийн шатны тайланг боловсруулж байна. Зөвлөмжийн хэрэгжилттэй холбогдуулан нэмэлт гэрээ байгуулан хугацаа сунган ажиллаж байна.	Эцсийн шатанд	Норм
1.1.8	БНБД 32.02.11 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" нормыг шинэчлэн боловсруулах	299,943,334	89,983,000	209,960,334	-		"ТБЭТ" ХХК 2023/03-07	Дунд шатны тайланд Редац, шүүмжийн ажлын хэсгээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу шаардлагатай нэмэлт сайжруулалтыг гүйцэтгэж байна. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа асуудлаар Зөвлөхөөс хүсэлт ирүүлээд байгаа тул судалж, шийдвэрлэхээр ажиллаж байна.	Дунд шатанд	Норм

№	Төсөл, арга хэмжээний чиглэл, нэр	Гэрээний дүн, ₮	Өмнө олгосон дүн, ₮	Санхүүжилт		Хэрэгжүүлэх байгууллага, гэрээ №	Биелэлт	Явц	Төрөл
				2024-2025 онд олгох дүн, ₮	2024 онд олгосон	Үлдэгдэл			
1.1.9	"Авто зам, замын байгууламжийн нормативт хугацааны суурь норм"-ыг шинэчлэх	85,800,000	51,480,000	34,320,000	-	34,320,000	Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн шатны тайланд редакц, шүүмжийн ажлын хэсгээс гаргасан санал зөвлөмжийн дагуу шаардлагатай нэмэлт сайжруулалтыг гүйцэтгэж, Авто замын салбарын Шинжлэх ухаан технологийн дэд зөвлөл болон Зам тээврийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах нэмэлт гэрээ байгуулан хугацаа сунган ажиллаж байна.	Эцсийн шатанд	Норм
1.1.10	Гүүр барих нормативт хугацааг шинэчлэн боловсруулах							Эцсийн шатанд	Норм
1.1.11	Авто зам, гүүрийн барилга, засвар арчлалтын ажлын үе шатны ажлуудад ноогдох ИТА-ны цагийн томьёосон норм боловсруулах							Эцсийн шатанд	Норм
